



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Доду Очид

№

82

танай

-ны №

-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 21,150.8 мянган төгрөгийн хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрийг биелүүлж ажилаагүй, ажил гүйлгээг бүртгэхдээ НБББББ-ыг мөрдөөгүй зэрэг зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, СНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний авсан нотолгоо аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой болно.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв нь байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлснийг 99.0 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	337,204,258.06	241,965,797.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	200,442,363.79	104,823,711.73
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	200,442,363.79	104,823,711.73
31210	Төгрөг	200,442,363.79	104,823,711.73
31211	Төрийн сангийн харилцах	200,442,363.79	104,823,711.73
33	АВЛАГА	0.00	18,005,092.31
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	5,198,367.31
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	12,806,725.00
35	БАРАА МАТЕРИАЛ	136,761,894.27	119,136,993.12
35100	Түүхий эд материал	90,944,644.15	77,775,288.09
35110	Тусгай зориулалттай материал	10,707,650.00	6,044,600.00
35130	Эм боох материал	80,236,994.15	71,730,688.09
35400	Хангамжийн материал	45,817,250.12	41,361,705.03
35410	Бичиг хэргийн материал	4,465,347.50	710,480.00
35420	Аж ахуйн материал	38,597,686.62	38,458,927.23
35440	Түлш, шатах тослох материал	2,754,216.00	1,987,371.00
35460	Хүнсний материал	0.00	204,926.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	736,434,041.84	688,856,596.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	736,434,041.84	688,856,596.72
39200	Биет хөрөнгө	731,306,121.12	684,009,751.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	494,050,655.00	498,438,445.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,412,272.37)	(52,615,828.29)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,736,434.00	50,436,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,375,064.69)	(39,211,434.01)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	256,243,579.33	277,794,079.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,982,063.93)	(146,350,444.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,191,490.00	42,181,490.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,807,416.80)	(16,282,984.36)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,000,000.00	4,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,466,667.16)	(2,666,667.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	79,483,300.00	75,095,510.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,355,852.26)	(6,808,848.92)
39300	Биет бус хөрөнгө	5,127,920.72	4,846,845.68
39302	Хуримтлагдсан элэгдэл	(796,379.28)	(1,077,454.32)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,073,638,299.90	930,822,393.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	9,151,777.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	9,151,777.00
41300	Өглөг	0.00	9,151,777.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	9,151,777.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,073,638,299.90	921,670,616.88
51	Засгийн газрын хувь оролцоо	1,073,638,299.90	921,670,616.88
51100	Засгийн газрын оруулсан капитал	156,678,198.05	156,678,198.05
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	156,678,198.05	156,678,198.05
51200	Хуримтлагдсан үр дүн	496,688,078.57	344,720,395.55
51210	Өмнөх үеийн үр дүн	(325,599,945.94)	496,688,078.57
51220	Тайлант үеийн үр дүн	822,288,024.51	(151,967,683.02)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,073,638,299.90	930,822,393.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,662,819,306.59	710,376,203.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	935,090,506.59	20,657,470.92
120	Нийтлэг татварын бус орлого	935,090,506.59	20,657,470.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,245,200.00	251,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	251,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,245,200.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	763,715,172.99	15,719,488.96
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	157,130,133.60	4,686,981.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	727,728,800.00	689,718,732.36
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,810,400.00	67,798,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,810,400.00	67,798,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	671,918,400.00	621,920,632.36
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	671,918,400.00	621,920,632.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	840,531,282.08	862,343,886.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,531,282.08	862,343,886.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,607,334.25	835,548,939.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,270,688.40	489,075,433.87
210101	Үндсэн цалин	234,836,022.97	265,598,893.89
210102	Нэмэгдэл	143,783,367.52	177,319,653.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,006,000.00	12,022,820.39
210104	Урамшуулал	39,645,297.91	34,134,066.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,482,121.20	69,479,710.64
210201	Тэтгэврийн даатгал	29,659,067.65	48,106,410.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,119,421.55	5,343,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,278,737.17	4,274,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,269,271.49	1,068,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,155,623.34	10,686,599.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,244,502.17	37,262,153.44
210301	Гэрэл, цахилгаан	2,844,741.17	5,604,636.44
210302	Түлш, халаалт	26,506,421.00	27,697,237.00
210303	Цэвэр, бохир ус	2,893,340.00	3,960,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,587,173.00	42,447,114.97
210401	Бичиг хэрэг	6,741,020.00	11,017,367.50
210402	Тээвэр, шатахуун	11,533,313.00	9,766,845.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,511,980.00	2,584,203.60

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	220,000.00	145,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,580,860.00	18,933,698.87
2105	Нормативт зардал	120,553,197.33	101,544,629.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,751,495.33	84,327,376.54
210502	Хоол, хүнс	12,801,702.00	10,541,203.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	6,676,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,929,422.00	8,343,646.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,006,000.00
210604	Урсгал засвар	59,929,422.00	5,337,646.00
2107	Томилолт, зочны зардал	1,965,100.00	410,000.00
210702	Дотоод албан томилолт	1,965,100.00	410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,722,488.00	3,839,437.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,859,288.00	2,897,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	21,600.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,600.00	107,237.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,852,642.15	83,146,814.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,928,311.00	6,839,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,924,331.15	76,306,834.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,923,947.83	26,794,946.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,872,200.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,872,200.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,051,747.83	26,794,946.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,051,747.83	26,794,946.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	822,288,024.51	(151,967,683.02)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	822,288,024.51	(151,967,683.02)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	994,083,440.39	677,163,007.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,428,440.39	251,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,428,440.39	251,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,428,440.39	251,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	251,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,245,200.00	0.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	30,183,240.39	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	949,655,000.00	676,912,007.36
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,810,400.00	67,798,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,810,400.00	67,798,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	893,844,600.00	609,113,907.36
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	893,844,600.00	609,113,907.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	750,997,876.60	759,771,759.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,997,876.60	759,771,759.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,073,928.77	732,976,812.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,082,481.60	494,273,801.18
210101	Үндсэн цалин	225,828,262.82	270,797,261.20
210102	Нэмэгдэл	170,096,336.54	177,319,653.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,799,068.49	12,022,820.39
210104	Урамшуулал	24,358,813.75	34,134,066.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,152,600.00	69,479,710.64
210201	Тэтгэврийн даатгал	31,383,800.00	48,106,410.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,692,200.00	5,343,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,953,800.00	4,274,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	738,400.00	1,068,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,384,400.00	10,686,599.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,244,502.17	37,262,153.44
210301	Гэрэл, цахилгаан	2,844,741.17	5,604,636.44
210302	Түлш, халаалт	26,506,421.00	27,697,237.00
210303	Цэвэр, бохир ус	2,893,340.00	3,960,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,169,098.00	25,137,392.60
210401	Бичиг хэрэг	7,048,500.00	6,055,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,000,000.00	9,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,511,980.00	2,584,203.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	694,069.00	145,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,914,549.00	7,353,189.00

2105	Нормативт зардал	99,009,580.00	74,318,168.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,564,180.00	59,335,938.00
210502	Хоол, хүнс	13,207,000.00	12,401,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,238,400.00	2,581,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,320,440.00	14,747,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,110,600.00	920,000.00
210604	Урсгал засвар	41,209,840.00	13,827,070.00
2107	Томилолт, зочны зардал	1,965,100.00	410,000.00
210702	Дотоод албан томилолт	1,965,100.00	410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,970,900.00	3,839,437.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,107,700.00	2,897,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	21,600.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,600.00	107,237.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	55,000.00
210807	Газрын төлбөр	0.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,159,227.00	13,509,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,159,227.00	13,509,080.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,923,947.83	26,794,946.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,872,200.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,872,200.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,051,747.83	26,794,946.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,051,747.83	26,794,946.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	243,085,563.79	(82,608,752.06)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	42,643,200.00	13,009,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,643,200.00	13,009,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,643,200.00	13,009,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,643,200.00	13,009,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(42,643,200.00)	(13,009,900.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	200,442,363.79	(95,618,652.06)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	200,442,363.79
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200,442,363.79	104,823,711.73

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	156,678,198.05	420,272,023.28	(325,599,945.94)	251,350,275.39
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	(325,599,945.94)	251,350,275.39
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	822,288,024.51	822,288,024.51
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	496,688,078.57	1,073,638,299.90
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	496,688,078.57	1,073,638,299.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	496,688,078.57	1,073,638,299.90
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(151,967,683.02)	(151,967,683.02)
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	875,969,800.00	745,986,712.86	(129,983,087.14)	85.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,969,800.00	745,986,712.86	(129,983,087.14)	85.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	875,969,800.00	745,986,712.86	(129,983,087.14)	85.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,206,100.00	494,273,801.18	(74,932,298.82)	86.84
210101	Үндсэн цалин	335,962,500.00	270,797,261.20	(65,165,238.80)	80.60
210102	Нэмэгдэл	178,294,000.00	177,319,653.21	(974,346.79)	99.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,114,700.00	12,022,820.39	(11,091,879.61)	52.01
210104	Урамшуулал	31,834,900.00	34,134,066.38	2,299,166.38	107.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,150,700.00	69,479,710.64	(1,670,989.36)	97.65
210201	Тэтгэврийн даатгал	48,382,600.00	48,106,410.84	(276,189.16)	99.43
210202	Тэтгэмжийн даатгал	5,692,000.00	5,343,700.00	(348,300.00)	93.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,553,600.00	4,274,300.00	(279,300.00)	93.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,138,400.00	1,068,700.00	(69,700.00)	93.88
210205	Эрүүл мэндийн даатгал	11,384,100.00	10,686,599.80	(697,500.20)	93.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,198,100.00	37,262,153.44	(25,935,946.56)	58.96
210301	Гэрэл, цахилгаан	13,913,100.00	5,604,636.44	(8,308,463.56)	40.28
210302	Түлш, халаалт	43,925,000.00	27,697,237.00	(16,227,763.00)	63.06
210303	Цэвэр, бохир ус	5,360,000.00	3,960,280.00	(1,399,720.00)	73.89
2104	Хангамж, бараа материалын зардал	35,771,400.00	25,137,392.60	(10,634,007.40)	70.27
210401	Бичиг хэрэг	7,725,000.00	6,055,000.00	(1,670,000.00)	78.38
210402	Тээвэр, шатахуун	12,785,300.00	9,000,000.00	(3,785,300.00)	70.39
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,194,400.00	2,584,203.60	(610,196.40)	80.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,500.00	145,000.00	(585,500.00)	19.85
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,336,200.00	7,353,189.00	(3,983,011.00)	64.86
2105	Нормативт зардал	74,579,400.00	74,318,168.00	(261,232.00)	99.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,500,300.00	59,335,938.00	(164,362.00)	99.72
210502	Хоол, хүнс	12,453,800.00	12,401,230.00	(52,570.00)	99.58
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,625,300.00	2,581,000.00	(44,300.00)	98.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,100,000.00	27,756,970.00	(4,343,030.00)	86.47
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	6,939,900.00	(60,100.00)	99.14
210602	Тавилга	7,000,000.00	6,990,000.00	(10,000.00)	99.86
210604	Урсгал засвар	18,100,000.00	13,827,070.00	(4,272,930.00)	76.39
2107	Томилот, зочны зардал	2,120,600.00	410,000.00	(1,710,600.00)	19.33
210702	Дотоод албан томилот	2,120,600.00	410,000.00	(1,710,600.00)	19.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,742,500.00	3,839,437.00	(2,903,063.00)	56.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	2,897,200.00	(2,102,800.00)	57.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	720,000.00	(80,000.00)	90.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	0.00	(250,000.00)	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	107,237.00	(142,763.00)	42.89
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	55,000.00	(195,000.00)	22.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,500.00	0.00	(42,500.00)	0.00
210807	Газрын төлбөр	100,000.00	60,000.00	(40,000.00)	60.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	0.00	(50,000.00)	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,101,000.00	13,509,080.00	(7,591,920.00)	64.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,101,000.00	13,509,080.00	(7,591,920.00)	64.02
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	875,969,800.00	650,368,060.80	(225,601,739.20)	74.25

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,798,100.00	41,003,153.44	(26,794,946.56)	60.48
320001	Орон нутгийн төсвөөс	67,798,100.00	41,003,153.44	(26,794,946.56)	60.48
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	607,483,400.00	609,113,907.36	1,630,507.36	100.27
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	607,483,400.00	609,113,907.36	1,630,507.36	100.27
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,688,300.00	251,000.00	(200,437,300.00)	0.13
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	251,000.00	251,000.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	245,900.00	0.00	(245,900.00)	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	200,442,400.00	0.00	(200,442,400.00)	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	200,442,363.79	200,442,363.79	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	104,823,711.73	104,823,711.73	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21.00	21.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 287,963.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 266,813.1 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1,517.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 14,350.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5,283.1 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах алдаанууд ирсэн.

- Санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлийг 30,183.2 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлан ирүүлсэн,
- Санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнг 226,513.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, зэрэгцүүлсэн баланс гаргаагүй тайлан ирүүлсэн,
- Шилжин ирсэн үндсэн хөрөнгийг хандив гэж 5,676.3 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үзүүлэлт буруу сонгон авсан, 2,123.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого аваагүй,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 2,316.9 мянган төгрөгөөр дутуу тооцсон.

Санхүүгийн тайланг нийт 266,813.1 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулав.

3.1 Төлбөрийн акт

Тус байгууллагын 2023 оны цалингийн тооцооллыг шалгахад эмч, албан хаагч нарт гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллын олгох хувь хэмжээг дахин хянаагүйгээс нэмэгдэл цалинг 1,758.2 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5-дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрүүтэй олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 5,198.4 мянган төгрөгийн авлага, 9,151.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан ,баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодогч Г.Алтанзулд Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 07 сарын 06-ны өдрийн Б/93 тоот тушаалаар 842.4 мянган төгрөгийн балансын урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан цалингийн сангаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 3.2. "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно" гэсэн заалтыг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайлангийн орлого зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад НБББББ-ийг мөрдөөгүй, дансны ангилал буруу бүртгэсэн, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, гүйцэтгэлийн тайлан мэдээ, дэмжих нотлох баримтгүй, хүчин төгөлдөр бус баримтаар 4,200.1 мянган төгрөгийн бараа, ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй, бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

3. Үндсэн хөрөнгө бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын жилийн эцсийн тооллогын тайланг хянан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичдэггүй, тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэдэггүй, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, тооллогын комиссын тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж дүгнэлт гаргаагүй, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн

67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна", 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах", 72.4-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн ба "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж байх, үндсэн хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх, элэгдлийн тооцооллыг давтан шалгах, зөвлөмж хүргүүлэх.

4. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын 2023 оны цалингийн тооцооллыг шалгахад эмч, албан хаагч нарт гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллын олгох хувь хэмжээг дахин хянаагүйгээс нэмэгдэл цалинг 240.6 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20.2.5-дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд залруулах	1	30,183.2			1	30,183.2	1	30,183.2				
Санхүүгийн тайланд залруулах	1	226,513.2			1	226,513.2	1	226,513.2				
Үндсэн хөрөнгө орлого авах	1	7,799.8	1	7,799.8			1	7,799.8				
Элэгдэл дутуу тооцсон	1	2,316.9	1	2,316.9			1	2,316.9				
	4	266,813.1	2	10,116.7	2	256,696.4	4	266,813.1	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа лтны тоо	Тоо	Дүн
Тооллого дүгнээгүй	1	0.0					1	0.0				
Бараа материал зарцуулалт	1	4,200.1					1	4,200.1				
Балансын урамшуулал	1	842.4					1	842.4				
Өр төлбөр үүсгэсэн	1	9,151.7			1	9,151.7						
Авлага үүсгэсэн	1	5,198.4			1	5,198.4						
Цалингийн хувь хэмжээ буруу тооцсон	1	240.6			1	240.6						
Цалингийн илүү олгосон	1	1,517.6	1	1,517.6								
Дүн	6	21,150.8	1	1,517.6	2	14,590.7	3	5,042.5	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан цалингийн зардлаас бусад орлогын 8,339.5 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	8,339.5					1	8,339.5
Дүн	1	8,339.5	-	-	-	-	1	8,339.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	8,339.5	-	-	-	-	1	8,339.5